

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД, САНГИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр

Дугаар А/23, 27

Улаанбаатар хот

АРГАЧЛАЛ, ЗАРДЛЫН НОРМАТИВ БАТЛАХ ТУХАЙ

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. "Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив"-ыг хавсралтаар баталсугай.
2. Аргачлал, зардлын норматив ашиглан хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлыг аймаг, нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын газар, хэлтэст хуваарилж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Н.Баярмаа/, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар /Г.Батдорж/-т тус тус даалгасугай.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН, ХАМГААЛЛЫН САЙД А.АРИУНЗАЯА
САНГИЙН САЙД Б.ЖАВХЛАН